

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/13/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2022 он

Хөвсгөл аймаг Төрийн Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 88095436 Цахим хаяг: [Davaanyamb@audit.gov.mn](mailto:Davaanyamb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Отгонбаяр  
Утас: 89306788 Цахим хаяг: [otgonbayard@audit.gov.mn](mailto:otgonbayard@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт.....	3
<b>2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....</b>	<b>4</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
<b>2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....</b>	<b>8</b>
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	9
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга.....	9
<b>Зардлын данс.....</b>	<b>11</b>
<b>4.1 Ерөнхий зүйл.....</b>	<b>15</b>
<b>4.2 Материаллаг байдал.....</b>	<b>15</b>
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....</b>	<b>15</b>
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....</b>	<b>15</b>
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....</b>	<b>15</b>
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....</b>	<b>16</b>
<b>4.5.1 Завсрын аудитын талаар.....</b>	<b>16</b>
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....</b>	<b>16</b>
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	16
5.1 Төлбөрийн акт.....	17
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар зөвлөмж хүргүүлээгүй байна.....	17
5.2 Албан шаардлага.....	17
Албан шаардлага хүргүүлээгүй болно.....	17
5.3 Зөвлөмж.....	17

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СДОА	Сум дундын ойн анги



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.24 № 01/298  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

УЛААН-УУЛ СУМЫН ТӨСВИЙН  
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ Н.БАТБАЯР  
ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Улаан-Уул сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаан-Уул сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагуудыг улсын төсөвт шилжүүлснээр нийт хөрөнгө 3,169.0 сая төгрөгөөр буюу 61 хувиар буурсан байна.

#### Аудитын гол асуудал

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 17.2 сая төгрөгийг төвлөрүүлэх зөвлөмж хүргүүллээ.

#### Бусад мэдээлэл

Улаан-Уул сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч Хөвсгөл аймгийн Засаг даргатай 7 чиглэлээр 121 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг 68.6 хувиар дүгнүүлсэн байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан /мянган төгрөгөөр/

	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>854,536.9</b>	<b>437,780.4</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>127,080.6</b>	<b>165,010.0</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>286,945.6</b>	<b>186,133.5</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>440,510.7</b>	<b>16,637.0</b>
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,341,092.5</b>	<b>1,588,223.1</b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	<b>18,784.0</b>	<b>70,000.0</b>
<b>37300</b>	<b>Урт хугацаат зээл</b>	<b>18,784.0</b>	<b>70,000.0</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>4,322,308.5</b>	<b>1,588,223.1</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>4,000,534.1</b>	<b>1,423,467.4</b>
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>321,774.4</b>	<b>164,755.7</b>
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,195,629.4</b>	<b>2,026,003.5</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,644.5</b>	<b>2,022.5</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,644.5</b>	<b>2,022.5</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>2,644.5</b>	<b>2,022.5</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,192,984.9</b>	<b>2,023,981.0</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>5,192,984.9</b>	<b>2,023,981.0</b>
<b>51100</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал</b>	<b>1,708,031.3</b>	<b>582,884.8</b>
<b>511002</b>	<b>Орон нутгийн төсвийн эруулсан хөрөнгө</b>	<b>1,708,031.3</b>	<b>582,884.8</b>
<b>51101</b>	<b>Өмч /төрийн/ /ТӨҮГ/</b>	<b>134,530.9</b>	<b>134,530.9</b>
<b>51106</b>	<b>Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/</b>	<b>37,027.8</b>	<b>37,027.8</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,259,007.2</b>	<b>757,669.5</b>
<b>51300</b>	<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	<b>1,054,387.6</b>	<b>511,868.0</b>
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>5,195,629.4</b>	<b>2,026,003.5</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>5,232,107.5</b>	<b>1,224,069.3</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>165,158.6</b>	<b>387,620.6</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>56,259.9</b>	<b>255,142.8</b>
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>56,259.9</b>	<b>272,262.4</b>
<b>1101</b>	<b>Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт</b>	<b>0.0</b>	<b>-17,119.6</b>
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>15,302.0</b>	<b>42,354.6</b>
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>93,596.7</b>	<b>90,123.2</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>671,753.2</b>	<b>26,326.7</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>671,753.2</b>	<b>26,326.7</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,395,195.6</b>	<b>810,122.0</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,731,963.5</b>	<b>1,172,892.6</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,731,963.5</b>	<b>1,172,892.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,845,635.9</b>	<b>1,134,601.7</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,278,067.3</b>	<b>447,959.6</b>
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>306,832.2</b>	<b>55,910.0</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>121,415.1</b>	<b>146,643.6</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>133,563.6</b>	<b>146,094.9</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>63,011.9</b>	<b>29,544.5</b>
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,147.7</b>	<b>3,300.0</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>47,976.8</b>	<b>42,149.2</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>487,773.8</b>	<b>262,999.8</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>886,327.6</b>	<b>38,290.9</b>

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	500,144.0	51,176.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	89,911.7	3,110,737.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	410,232.3	-3,059,560.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,833,187.2	1,318,109.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	165,158.6	387,620.6
110	Орлогын албан татвар	56,259.9	255,142.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	56,259.9	272,262.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-17,119.6
113	Хөрөнгийн албан татвар	15,302.0	42,354.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	93,596.7	90,123.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	13,671.9	6,422.9
1181	Газрын төлбөр	1,799.9	7,012.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	78,124.8	76,687.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	122,032.9	118,431.4
120	Нийтлэг татварын бус орлого	122,032.9	118,431.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,545,995.7	812,057.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,437,119.7	1,204,079.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,437,119.7	1,204,079.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,334,545.5	907,563.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,319,453.6	490,398.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	319,294.2	68,421.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	122,265.7	149,703.4
2104	Хангамж, бараа материалын зардал	157,198.5	86,202.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	79,112.9	29,544.5
2107	Томилолт, зочны зардал	5,147.7	3,300.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,891.2	46,037.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,129.6	33,955.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,574.2	296,515.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	396,067.5	114,029.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	340,998.1	6,100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	340,998.1	6,100.0
2200	Дотоод эх үүсвэрээр	340,998.1	6,100.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-340,998.1	-6,100.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-26,000.0	-70,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	26,000.0	70,000.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	29,069.4	37,929.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	98,011.2	127,080.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	127,080.6	165,010.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,123,433.1	4,123,433.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	666,366.2	666,366.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,789,799.4	4,789,799.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-7,046.8	-7,046.8
9	Тайлант үеийн үр дүн	410,232.3	410,232.3
10	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,192,984.9	5,192,984.9
11	2022 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	5,192,984.9	5,192,984.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-109,119.5	-109,119.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,083,865.4	5,083,865.4
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-324.0	-324.0
19	Тайлант үеийн үр дүн	-3,059,560.4	-3,059,560.4
20	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,023,981.0	2,023,981.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,356,800.2</b>	<b>1,200,437.4</b>	<b>156,362.8</b>	<b>88.5</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,263,800.2</b>	<b>1,130,437.4</b>	<b>133,362.8</b>	<b>89.5</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>862,124.6</b>	<b>842,920.3</b>	<b>19,204.3</b>	<b>97.8</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>457,968.4</b>	<b>447,959.7</b>	<b>10,008.8</b>	<b>97.8</b>
210101	Үндсэн цалин	389,576.6	359,272.7	30,303.9	92.2
210102	Нэмэгдэл	63,023.8	87,212.1	-24,188.3	138.4
210104	Урамшуулал	5,368.0	1,302.9	4,065.1	24.3
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>58,428.0</b>	<b>55,910.0</b>	<b>2,518.0</b>	<b>95.7</b>
210201	Тэтгэврийн даатгал	39,742.9	35,893.6	3,849.3	90.3
210202	Тэтгэмжийн даатгал	4,661.8	6,666.2	-2,004.4	143.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,740.4	3,584.1	156.3	95.8
210204	Ажилгүйдлийн даатгал	931.5	1,064.7	-133.2	114.3
210205	Эрүүл мэндийн даатгал	9,351.4	8,701.5	649.9	93.1
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>144,643.3</b>	<b>144,120.6</b>	<b>522.7</b>	<b>99.6</b>
210301	Гэрэл, цахилгаан	31,427.3	28,888.0	2,539.3	91.9
210302	Түлш, халаалт	107,716.0	111,482.6	-3,766.6	103.5
210303	Цэвэр, бохир ус	5,500.0	3,750.0	1,750.0	68.2
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>63,975.5</b>	<b>63,562.1</b>	<b>413.4</b>	<b>99.4</b>
210401	Бичиг хэрэг	5,300.0	5,221.2	78.8	98.5
210402	Тээвэр, шатахуун	43,955.5	43,957.5	-2.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,100.0	4,089.0	11.0	99.7
210404	Ном, хэвлэл	920.0	799.9	120.1	87.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000.0	1,869.5	130.5	93.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,700.0	7,625.0	75.0	99.0

Улаан-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>35,944.5</b>	<b>35,644.5</b>	<b>300.0</b>	99.2
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,100.0	4,800.0	300.0	94.1
210604	Урсгал засвар	30,844.5	30,844.5	0.0	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,300.0</b>	<b>3,300.0</b>	<b>0.0</b>	100.0
210702	Дотоод албан томилолт	3,300.0	3,300.0	0.0	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>26,162.0</b>	<b>20,988.4</b>	<b>5,173.7</b>	80.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,632.0	19,320.8	4,311.2	81.8
210803	Даатгалын үйлчилгээ	200.0	186.2	13.8	93.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200.0	200.0	0.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	80.0	80.0	0.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	850.0	793.0	57.0	93.3
210807	Газрын төлбөр	1,200.0	408.4	791.6	34.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>71,702.9</b>	<b>71,435.1</b>	<b>267.8</b>	99.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	69,783.7	69,515.9	267.8	99.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,919.2	1,919.2	0.0	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>401,675.6</b>	<b>287,517.2</b>	<b>114,158.4</b>	71.6
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>365,897.8</b>	<b>258,120.0</b>	<b>107,777.8</b>	70.5
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	365,897.8	258,120.0	107,777.8	70.5
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>35,777.8</b>	<b>29,397.2</b>	<b>6,380.6</b>	82.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,340.0	5,340.0	0.0	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,390.6	22,052.2	6,338.4	77.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,047.2	2,005.0	42.2	97.9
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>93,000.0</b>	<b>70,000.0</b>	<b>23,000.0</b>	75.3
230001	Эргэж төлөгдөх зээл	93,000.0	70,000.0	23,000.0	75.3
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,356,800.2</b>	<b>1,222,867.3</b>	<b>133,932.9</b>	90.1
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>263,227.7</b>	<b>263,227.7</b>	<b>0.0</b>	100.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	263,227.7	263,227.7	0.0	100.0
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>912,408.2</b>	<b>917,067.4</b>	<b>-4,659.2</b>	100.5
320001	Орон нутгийн төсвөөс	912,408.2	917,067.4	-4,659.2	100.5
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>181,164.3</b>	<b>42,572.1</b>	<b>138,592.2</b>	23.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	57,500.0	40,349.8	17,150.2	70.2
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000.0	2,222.3	2,777.7	44.5
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	118,664.3	0.0	118,664.3	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1	76,383.08	-76,383.08	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1	98,812.92	-98,812.92	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>143</b>	<b>143</b>	<b>0</b>	
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>3</b>	<b>3</b>	<b>0</b>	
610001	Төсвийн байгууллага	2	2	0	
610002	Төсвөөс гадуур байгууллага	1	1	0	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>70</b>	<b>70</b>	<b>0</b>	
620001	Удирдах ажилтан	11	11	0	

620002	Гүйцэтгэх ажилтан	13	13	0
620003	Үйлчлэх ажилтан	46	46	0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>70</b>	<b>70</b>	<b>0</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9	0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	52	52	0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9	9	0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>13,121.7</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>13,121.7</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>11,186.7</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>4,008.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	738.0
210302	Түлш, халаалт	3,270.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,367.9</b>
210401	Бичиг хэрэг	1,367.9
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,810.8</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,810.8
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,935.0</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,935.0</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,935.0
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>13,121.7</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>13,121.7</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,010.8
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,110.9
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.00</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Улаан-Уул сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь “Төрийн үйлчилгээг шуурхай иргэн бүрд тэгш хүртээмжтэй, нээлттэй ил тод, өрх гэр бүлийн амьжиргааг дээшлүүлэх жижиг дунд үйлдвэрлэл мал аж ахуйг хөгжүүлж ажлын байр нэмэгдүүлэх замаар ажилгүйдэл ядуурлыг бууруулах, иргэдээ эрүүл аюулгүй орчинтой шинэ суманд сэтгэл хангалуун амьдруулах” зорилгыг дэвшүүлэн ажилласан байна. Дээрх зорилгыг хэрэгжүүлэхээр дараах чиглэлүүдээр 84 зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

Үүнд:

- Иргэдийн сэтгэл ханамж, эрх зүйн боловсролд суурилсан төрийн удирдлага

- Боловсрол, соёл урлаг, спорт, эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлого
- Хөдөө аж ахуй, байгаль орчинд ээлтэй бодлого
- Иргэдийн хүсэл сонирхолд тулгуурласан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, жижиг дунд үйлдвэрийн бодлого
- Иргэдэд ээлтэй аюулгүй байдлын бодлого

Тус сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилт 68.6 хувьтай дүгнэгдсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

#### Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Төсвийн орлого бүрдүүлэлт, Сум хөгжүүлэх сангийн гүйцэтгэл, түүний үр дүнд, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын хэрэгжилтэд 2 удаа хяналт хийж хяналтаар илэрсэн зөрчил, гаргасан алдаа дутагдлыг тухай бүр нягтлан бодогчид бичгээр болон амаар зөвлөмж өгч хэрэгжилтээ тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас нэгдсэн байдлаар боловсруулан мөрдүүлж байна. Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд томоохон өөрчлөлт ороогүй байна. Тайлант онд шинээр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлсэн.

Дотоод хяналтын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын нэгжийн гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтын нэгжээс шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаан-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-д нийцүүлэн нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,169.6 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	127.1	165.0	37.9
Авлага	286.9	186.1	-100.8
Бараа материал	440.5	16.6	-423.9
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>854.5</b>	<b>367.7</b>	<b>-486.8</b>
Урт хугацаат хөрөнгө оруулалт	18.8	70.0	51.2
Үндсэн хөрөнгө	4,322.3	1,588.2	-2,734.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,195.6</b>	<b>2,025.9</b>	<b>-3,169.6</b>

Улаан-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Өр төлбөр	2.6	2.0	-0.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,192.9	2,023.9	-3,169.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>5,195.6</b>	<b>2,025.9</b>	<b>-3,169.6</b>

Эх сурвалж: Улаан-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, өр төлбөр данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө, бараа материал, засгийн газрын хувь оролцоо данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн өсөлт бууралтад сум хөгжүүлэх сангийн зээлийн мэдээллийг Монгол банкны санд бүртгүүлж мэдээлдэг болсон, сумын Засаг даргын захирамжаар хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах ажлын хэсгийг томилж ажиллуулсан болон мөн хугацаа хэтэрсэн зээлийг анхан шатны шүүхэд шилжүүлснээр зээлийн эргэн төлөлт нэмэгдсэн зэрэг нь нөлөөлсөн байна.
- Авлага 100.8 сая төгрөгөөр буурч 186.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба үүнээс Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэл 39 иргэний 155.8 мянган төгрөг байна. 39 иргэний 145.2 сая төгрөгийн зээл, хүүгийн авлагын 10.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба шүүхээр шийдвэрлүүлэх шатанд шатанд явж байна.
- Бараа материалын дансны үлдэгдэл 423.9 сая төгрөгөөр буурахад Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хөрөнгө шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна. Үүнд: Улаан-Уул сумын Ерөнхий боловсролын сургуулийн 171.2 сая төгрөг, Соёлын төвийн 7.9 сая төгрөг, Эрүүл мэндийн төвийн 155.6 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэгийн 92.9 сая төгрөг, Засаг даргын Тамгын газар 2.4 сая, Баяншишгэд СДОА 1.3 сая төгрөгийн материал шилжүүлсэн байна.
- Урт хугацаат хөрөнгө оруулалт 51.2 сая төгрөгөөр өсөж 70.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Хоршоо хөгжүүлэх сангийн 1 жилээс дээш хугацааны дараа төлөгдөх 2 аж ахуйн нэгжтэй холбоотой зээлийн үлдэгдэл юм.
- Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 2,719.2 сая төгрөгөөр буурахад Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна. Үүнд: Соёлын төвийн 245.3 сая төгрөг, Ерөнхий боловсрол сургуулийн 1,589.3 сая төгрөг, Эрүүл мэндийн төвийн 705.8 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэгийн 178.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотойгоор буурсан байна.
- Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 2.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2.0 сая төгрөг болж 0.6 сая төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт №2 Өр төлбөрийн үлдэгдэл Байгууллага**

	Эхний үлдэгдэл	/сая төгрөг/ Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
ОНЕОрлого	0.1	0	0.1
Баяншишгэд СДОА	2.2	2.0	-0.2
Хүүхдийн цэцэрлэг	0.4	0.0	-0.4
<b>Нийт дүн</b>	<b>2.6</b>	<b>2</b>	<b>0.6</b>

Эх сурвалж: Улаан-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны нийт өрийн дүнд Баяншишгэд СДОА-гийн өглөг 51.3%-ийг эзэлж байна.

- Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 5192.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2023.9 сая төгрөг болж 3,169.0 сая төгрөгөөр буурсан байна.

**Хүснэгт №3 Засгийн газрын хувь оролцоо**

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1708.0	582.8	-1125.2
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	134.5	134.5	0
Хуримтлагдсан үр дүн	2,259.0	757.7	-1501.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,054.4	511.9	-542.5
Нийт дүн	5,192.9	2,023.9	-3,169.0

Эх сурвалж: Улаан-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 3,169.0 сая төгрөгөөр буурч тайлант үеийн үр дүнд нөлөөлсөн байна.

### Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт 2,300.1 сая төгрөгийг орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 2,932.0 сая төгрөг буюу 43.9 хувиар буурсан байна.

Санхүүгийн үр дүнгийн нийт орлого

#### Хүснэгт №4

Үзүүлэлт	/сая төгрөг/			
	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Татварын орлого	165.2	387.6	222.4	234.6
Татварын бус орлого	671.7	138.3	-533.4	-20.5
Тусламж санхүүжилтийн орлого	4,395.2	1,774.2	-2,621.0	-40.4
<b>Нийт дүн</b>	<b>5232.1</b>	<b>2300.1</b>	<b>-2932.0</b>	<b>-43.9</b>

Эх сурвалж: Улаан-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Орлогын дүн буурсан шалтгаан нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын тайлан улсын төсөвт шилжсэнтэй холбоотойгоор үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, санхүүжилтийн орлого зэрэг нь нөлөөлсөн байна. Мөн татварын орлого өссөн нь орон нутгийн орлого давж биелсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1448.4 сая төгрөгийн зарлагын давхардсан 13 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 1448.4 сая төгрөгийн зарлагын давхардсан 13 гүйлгээ устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

### Зардлын данс

#### Хүснэгт №5: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү	Хувь
Үйл ажиллагааны зардал	4,731.9	2,093.4	-2,638.5	-44.2
Үйл ажиллагааны бус зардал	89.9	3,266.3	3,176.4	3,633.0
<b>Нийт дүн</b>	<b>4,821.8</b>	<b>5,359.7</b>	<b>537.9</b>	<b>3,588.8</b>

Эх сурвалж: Улаан-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Нийт зардлын дүн өссөн нь гүйцэтгэл үр дүнгээр санхүүжих байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалыг шилжүүлэхдээ үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 1448.4 сая төгрөгийн зарлагын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төслийг харьяа байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Улаан-Уул сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 02 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрт зориулан 1,435.5 сая төгрөгийн төсөв баталснаас 1,001.0 сая төгрөгийг урсгал зардалд, 372.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, зээл олгоход 62.5 сая төгрөгийг зарцуулахаар батлагджээ. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 05 дугаар тогтоолоор орон нутгийн татварын орлогыг 70.0 сая төгрөгөөр, Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 71.9 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 21.9 сая төгрөгөөр, нийт 163.8 сая төгрөгөөр бууруулж тодотгол хийсэн байна. Энэ нь Аймгийн төсөвт тодотгол хийсэн, боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагын төрийн үйлчилгээний ажилчдын цалин улсын төсөвт шилжсэнтэй холбоотой орон нутагт ирэх санхүүжилт, цалингийн татварын орлого, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг буурснаас шалтгаалсан байна.

Нийт зарлагыг 378.6 сая төгрөгийг орон нутгийн орлогоос, 263.2 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 533.8 сая төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 118.7 сая төгрөгийг давсан орлого, дансны үлдэгдлээс, 62.5 сая төгрөгийг зээлийн эргэн төлөлт болон хүүгийн орлогоос тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Улаан-Уул сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 05 дугаар дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэгийг 93.8 сая төгрөгийн хасах тодотгол хийж төсвийг 1,356.8 сая төгрөгөөр баталсан байна. Тогтоолын 2 дугаар хавсралтаар орон нутгийн ерөнхий орлогын дансны 2021 оны үлдэгдэл 2.6 сая төгрөг, 2021 оны давсан орлого 29.7 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 15.9 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл 33.7 сая төгрөгийг тус тус нэмж баталсан. Хасах тодотгол хийсэн нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагад ажиллагсдын цалинг улсын төсвөөс санхүүжүүлэх болсонтой холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 76.4 сая төгрөг дээр нэмж орон нутгийн төсвийн санхүүжилт 940.6 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 40.3 сая төгрөг, хүүгийн эргэн төлөлт 2.2 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангаас 263.2 сая төгрөгийн санхүүжилтийн орлого орж, 1,322.7 сая төгрөг зарцуулж, орон нутгийн төсөвт 23.5 сая төгрөг төвлөрүүлж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 98.8 сая төгрөг байна. Төсвийн орлого бүрдүүлэлтийг харуулбал:

#### Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Улаан-Уул сумын ИТХ-ын 2022 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 02 дугаар тогтоолд зааснаар Улаан-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 448.5 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр анх баталж, сумын ИТХ-ын 2022 оны 06 сарын 27-ны өдрийн 05 дугаар тогтоолоор үл хөдлөх хөрөнгийн татварыг 70.0 сая төгрөгөөр бууруулж тодотгол хийсэн байна. Гүйцэтгэлээр 390.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 103.1 хувийн биелэлттэй байна.

#### Хүснэгт №06. Төвлөрүүлэх орлого

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
			Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	15.5	18.2	2.7	117.4
Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	190.0	222.8	32.8	117.3
ХХОАТ буцаалт	-27.6	-17.1	10.5	62.0
Шууд бус орлого	5.5	1.1	-4.4	20.0
Хөрөнгө борлуулсны орлого	1.4	1.8	0.4	128.6
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	37.1	32.5	-4.6	87.6
Бууны албан татвар	2.6	2.3	-0.3	88.5
Малд ногдуулах албан татвар	50.0	35.9	-14.1	71.8
Улсын тэмдэгтийн хураамж	7.3	4.4	-2.9	60.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.5	0.0	-0.5	0

Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4.0	1.6	-2.4	40
Газрын төлбөр	3.5	3.6	0.1	102.8
Ойн нөөц ашигласны төлбөр	77.9	72.5	-5.4	93.1
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	1.1	0.6	-0.5	54.5
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.3	0.3	0	100
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	3.4	3.3	-0.1	72.5
Торгуулийн орлого	4.0	2.9	-1.1	72.5
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	2.0	3.4	1.4	170.0
<b>ОРОН НУТГИЙН ОРЛОГО</b>	<b>378.5</b>	<b>390.1</b>	<b>11.6</b>	<b>103.1</b>

Эх сурвалж: Улаан-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Улаан-Уул сумын орон нутгийн орлого 11.6 сая төгрөгөөр давж биелэхэд Цалин хөлс түүнтэй адилтгах орлого 32.8 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлого 2.7 сая төгрөгөөр, Газрын төлбөр 0.1 сая төгрөгөөр, Хөрөнгө борлуулсны татвар 0.4 сая төгрөгөөр давж биелсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

Орон нутгийн орлогоос 10 нэр төрлийн 35.6 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Орон нутгийн төлөвлөгөө биелээгүй орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Үл хөдлөх хөрөнгийн орлого 4.6 сая төгрөг, шууд бус орлого 4.4 сая төгрөг, малд ногдуулах албан татвар 14.1 сая төгрөг, бууны татвар 0.3 сая төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 0.4 сая төгрөг, Улсын тэмдэгтийн хураамж 2.9 сая төгрөг, хог хаягдлын хураамж 2.4 сая төгрөг, байгалийн нөөцийн төлбөр хураамжууд 6.0 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Улсын төсвийн орлого 146.3 %, аймгийн төсвийн орлого 141.4 %, орон нутгийн орлого 103.1 %-иар тус тус биелсэн байна.

**Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:** Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 15.2 сая төгрөгөөр төлөвлөж 21.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 141.4 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №07: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	ААНОАТ	0.6		-0.6	0
2	Үл хөдлөх хөрөнгийн татвар	0.06	0.06		100
2	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	12.0	17.8	6.5	148.3
3	Зам ашигласны төлбөр	2.6	3.5	0.9	134.6
	<b>Нийт дүн</b>	<b>15.2</b>	<b>21.5</b>	<b>6.8</b>	<b>141.4</b>

Эх сурвалж: Улаан-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын гүйцэтгэлд Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар 6.5 сая төгрөгийг давж биелүүлсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

**Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:** Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 6.9 сая төгрөгөөр төлөвлөж 10.1 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 3.2 сая төгрөг буюу 46.3 хувиар давуулан биелүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №08: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	3.9	3.6	-0.3	92.3
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	2.4	4.0	1.6	166.6
3	Агаарын бохирдлын төлбөр	0.6	2.5	1.9	416.7

<b>Нийт дүн</b>	<b>6.9</b>	<b>10.1</b>	<b>3.2</b>	<b>146.3</b>
-----------------	------------	-------------	------------	--------------

Эх сурвалж: Улаан-Уул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

### Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 1,356.8 сая төгрөгөөр төлөвлөж, 1200.4 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 88.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 62.5 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөж гүйцэтгэлээр 42.5 сая төгрөгийн зээл, хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлт төлөгдсөн байна. Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлт өндөр гүйцэтгэлтэй байгаа нь тус сангийн зээлийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн сантай холбож зээлжих зэрэглэлд хамааруулж эхэлсэнтэй холбоотой байна.

### Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрт зориулан 1,356.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,263.8 сая төгрөгийг урсгал зардалд, 93.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хаасан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 917.1 сая төгрөгийг орон нутгийг хөгжүүлэх сангаас 263.2 сая төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 42.5 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1200.4 сая төгрөг буюу 88.4 хувьтай байгаа нь Сангийн яамнаас тэвчиж болох зардлыг санхүүжүүлээгүйтэй холбоотой байна. Төсвийн хэмнэлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 10.0 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2.5 сая төгрөг
- Байгууллагатай холбоотой тогтмол зардал 0.5 сая
- Хангамж, бараа материалын зардал 0.4 сая төгрөг
- Эд хогшил, урсгал засварын зардал 0.3 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 5.2 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 0.3 сая төгрөг
- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал 6.3 сая төгрөг
- Засгийн газрын дотоод шилжүүлэг 103.7 сая төгрөг

Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны гүйцэтгэлийн талаар:

ИТХ-ын 2022 оны 06 сарын 27-ны №05-р тогтоолоор ОНХС-ийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах 35 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 372.0 сая төгрөгийн төсөв баталж, 23 ажлын 258.1 сая төгрөгийн ажил хэрэгжсэн ба 12 ажилд тендер зарлагдаагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар тендерийн орлого 0.4 сая төгрөг, спорт заал, ухаалаг худгийн орлого 7.3 сая төгрөг, статистикийн хэлтсээс мал тооллогын зардал 3.2 сая төгрөг, усны хөнгөлөлт 1.9 сая төгрөг аймгийн ИТХ-аас хамтарсан багийн үйл ажиллагааны зардалд 0.3 сая төгрөг нийт 13.1 сая төгрөгийн орлого орсон.

Гүйцэтгэлээр бараа үйлчилгээний зардалд 11.2 сая төгрөгийг зарцуулж, 1.9 сая төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улаан-Уул сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын Ахлах аудитор Д.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг Ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Улаан-Уул сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 03 дүгээр сарын 01-ний өдрийн 10/43 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,091.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 21.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 17.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд горим сорил хэрэгжүүлэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Улаан-Уул сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчилд 3 зөрчилд 3 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 9 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	-	2	-	66.7
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>66.7</b>

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж хүргүүлснээс 2 зөвлөмж хэрэгжиж, Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр хөрөнгө бэлтгэсэн 3 компанитай холбоотой 29.4 сая төгрөгийн ажил хэрэгжээгүй 66.7 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал: Орон нутгийн хөгжлийн сангийн авлагын барагдуулалтад анхаарах

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 53.7 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрсэн. Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой 1, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой 1, харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах 1 нийт 3 зөвлөмж хүргүүлж байна

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлогын данс болон харьяа 3 байгууллага, орон нутгийн 2 тусгай сангийн нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, бусад байгууллага, тусгай сангийн санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан ЗДТГ-ын санхүүгийн тайланд "Зөрчилгүй" дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 204.3 сая төгрөгийн 1 алдаа, зөрчил илэрсэн. Аудитаар илэрсэн зөрчилд үндэслэн албан шаардлага хүргүүлсэн байна.

## **5.1 Төлбөрийн акт**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар зөвлөмж хүргүүлээгүй байна.

## **5.2 Албан шаардлага**

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

Албан шаардлага хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

## **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

#### **1.1. Илрүүлэлт:**

Татварын орлогын төлөвлөгөөнөөс 11 нэр төрлийн 36.5 сая төгрөгийн орлогыг дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах.

### **2. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

#### **2.1. Илрүүлэлт:**

Хоршоо хөгжүүлсэн сангийн авлагын үлдэгдэл 225.8 сая төгрөг байна. Үүнээс 6 иргэн, 2 аж ахуйн нэгжийн 215.2 сая төгрөгийн зээл, хүүгийн авлагын 10.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 6 иргэний 16.8 сая төгрөг байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоо хөгжүүлэх сангийн журам"-ын 3.4.11.Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Сум хөгжүүлэх сангийн хугацаа хоцорсон зээл, хүүгийн үлдэгдлийг төвлөрүүлэх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх

### **3. ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийн талаар**

#### **3.1. Илрүүлэлт:**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 204.3 сая төгрөгийн 1 алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд илэрсэн алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

#### **3.2. Өгсөн зөвлөмж:**

Өөрийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн албан шаардлагыг хяналтдаа авч хэрэгжилтийг хангуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Алдаа зөрчлийг давтахгүй албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 204.3 сая төгрөгийн 1 алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд 204.3 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.	1												
Хоршоо хөгжүүлсэн сангийн авлагын үлдэгдэл 225.8 сая төгрөг байна. Үүнээс 39 иргэн, 2 аж ахуйн нэгжийн 215.2 сая төгрөгийн зээл, 10.6 сая төгрөгийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 11 иргэний 16.8 сая төгрөг байна.	1	16.8					1	16.8					
Орон нутгийн орлогын төлөвлөгөөг дутуу биелүүлсэн	1	36.5					1	36.5					
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>53.3</b>					<b>53.3</b>						
Харьяа байгууллагуудын зөрчил													
Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газар	1	204.3			1	204.3							
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>204.3</b>			<b>1</b>	<b>204.3</b>							

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН  
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:  
 АУДИТЫН МЕНЕЖЕР  
 БАТАЛГААЖУУЛСАН:  
 АХЛАХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Д.ЛОТГОНБАЯР ОГНОО: